

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:**

“5.2.Засгийн газар энэ хуулийн 5.1.5-д заасан жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно.”

#### **2/6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4 дэх хэсэг:**

“6.2.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ашиг сонирхлын зөрчилтэй болон энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хамаарал бүхий хүнийг томилохыг хориглоно.

6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгоход Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд заасан журмыг тус тус баримтлана.

6.4.Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, цуцлах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.“

#### **3/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:**

“8.1.4.харьяа нутаг дэвсгэрт байрлах энэ хуулийн 6.1.1-д заасан бүсийн дэглэмийг зөрчихөөс сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх.”

#### **4/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:**

“10.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах нь байнгын, түр гэсэн төрөлтэй байна. Агуулахын төрөл тус бүрт тавигдах шаардлага, агуулах хооронд эргэлт хийх журмыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.”

#### **5/11 дүгээр зүйлийн 11.7, 11.8 дахь хэсэг:**

“11.7.Энэ зүйлийн 11.1.7-д заасан санал гаргах эрх бүхий байгууллага нь тухайн хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

11.8.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт энэ хуулийн 11.1.1-д заасан шаардлагыг хангаагүй нь тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болно.”

#### **6/11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт:**

“11.1.1.хуулийн этгээдийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшдэг байх;”

#### **7/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:**

“12.4.Энэ зүйлийн 12.1.2, 12.3.4-т заасан санал гаргах эрх бүхий байгууллага нь тухайн хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан шийдвэрлэнэ.”

#### **8/14 дүгээр зүйлийн 14.8, 14.9 дэх хэсэг:**

“14.8.Тээвэрлэх тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тоо хэмжээг тогтоосон тээвэрлэх хуудсыг тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны бэлэн байдал, даацыг харгалзан мэргэжлийн хяналтын байгууллага олгоно.

14.9.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн харуул хамгаалалттай холбоотой зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.”

#### **9/15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.8, 15.9 дэх хэсэг:**

“15.4.Энэ зүйлийн 15.2.2-т заасан санал гаргах эрх бүхий байгууллага нь тухайн хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

15.5.Энэ хуулийн 15.3-т заасан тайлан гаргах журмыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

15.6.Тусгай шаардлага хангасан Монгол Улсын иргэнд тэсэлгээчний эрх олгоно.

15.7.Тэсэлгээчний эрх олгох, цуцлах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.8.Энэ хуулийн 15.2.1-д заасан мэргэжлийн ажиллах хүчинд тавих шаардлагыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

15.9.Энэ хуулийн 15.2-т заасан хуулийн этгээд нь түр агуулахыг тэсэлгээний ажил явуулах газарт байгуулна.”

**10/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:**

“16.4.Энэ хуулийн 16.1-д заасан этгээд нь энэ хуулийн 15.2-т заасан шаардлагыг хангасан тэсэлгээний ажил явуулах нэгжтэй, өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан байнгын агуулахтай байна.”

**11/17 дугаар зүйлийн 17.2, 17.3, 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8, 17.9, 17.10,17.11 дэх хэсэг:**

“17.2. Пиротехникийн хэрэгсэл нь ашиглалтын болон хэрэглээний гэсэн төрөлтэй байна.

17.3.Монгол Улсад ашиглах болон хэрэглэх пиротехникийн хэрэгслийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.4.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгоно.

17.5.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох хуулийн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлага тавина:

17.5.1.өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан байнгын агуулахтай;

17.5.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах аюулгүй ажиллагааны шаардлага хангасан мэргэжлийн боловсон хүчний талаар мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт авсан байх;

17.5.3.цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал авсан байх.

17.6.Пиротехникийн хэрэгслийг ашиглах хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна пиротехникийн хэрэгслийн операторчинтай, цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал авсан байна.

17.7.Пиротехникийн хэрэгслийн операторчны эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг цагдаагийн болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

17.8.Энэ хуулийн 17.5-д заасан хуулийн этгээд нь ашиглалтын пиротехникийн хэрэгслийг энэ хуулийн 17.6-д заасан хуулийн этгээдэд худалдана.

17.9.Хэрэглээний пиротехникийн хэрэгслийг худалдах хуулийн этгээдэд тавих шаардлагыг энэ хуулийн 5.1.4-т заасан Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрмээр зохицуулна.

17.10.Ашиглалтынхаас бусад пиротехникийн хэрэгслийг хэрэглэхэд иргэн, хуулийн этгээдээс тусгай нөхцөл шаардахгүй.

17.11.Энэ зүйлийн 17.3.2 болон 17.6-д заасан санал гаргах эрх бүхий байгууллага нь тухайн хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан шийдвэрлэнэ.”

### **12/23 дугаар зүйлийн 23.3, 23.4, 23.5, 23.6 дахь хэсэг:**

“23.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллага хяналт тавина.

23.4.Пиротехникийн хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдалд цагдаа, онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн байгууллага хяналт тавина.

23.5.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хадгалалтын үеийн галын аюулгүй байдал, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэнд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага хяналт тавина.“

### **13/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:**

“24.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

**2 дугаар зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “устгах” гэсний дараа “, тэсэлгээний ажил явуулах” гэж, мөн зүйлийн 4.1.10 дахь заалтын “дүгнэлт гаргах” гэсний дараа “эрх бүхий” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “тэсэрч дэлбэрэх бодис” гэсний өмнө өөрийн “эзэмшлийн газар дээр байгуулсан” гэж, мөн заалтын “байгууламж,” гэсний дараа “байнгын агуулах,” гэж, 13 дугаар зүйлийн “15.1” гэсний дараа “,16.1 “ гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “ашиглахдаа” гэсний дараа “энэ хуулийн 15.3, 15.6-д заасныг болон” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хэрэгслийн” гэсний дараа “үйлдвэрийн байр,” гэж, мөн хэсгийн “гэрээт” гэсний өмнө “галт зэвсэг эзэмших эрх бүхий” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “эрсдэл,” гэсний дараа “тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцан ажилладаг ажилтныг” гэж, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “ашигласан” гэсний дараа “, устгасан” гэж, мөн хэсгийн “тухай бүр” гэсний дараа “, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцан ажилладаг ажилтан, тэдгээрийг даатгалд хамруулсан болон ашиглаж байгаа тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн талаархи мэдээллийг жил бүр” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт:**

“6.1.2.тэсэлгээний ажил явуулах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;”

**2/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:**

“10.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**3/11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт:**

“11.1.6.цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх;.

**4/11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг:**

“11.5.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь хувьцаа эзэмшлийн хувь хэмжээнд гарсан өөрчлөлтийн талаархи мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын 5 өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

**5/12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2 дахь заалт:**

“12.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах аюулгүй ажиллагааны шаардлага хангасан өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан байнгын агуулахтай, ачиж буулгах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх, мэргэжлийн боловсон хүчний талаар мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт авсан байх;

12.1.2.цагдаагийн болон тагнуулын байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас санал авсан байх.”

**6/15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг:**

“15.3.Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон хяналтын хуудсыг үндэслэн үйл ажиллагаа явуулах бөгөөд тэсэлгээний ажлын

гүйцэтгэлийн тайлан гаргаж хүргүүлнэ.Тайланд тэсэлгээний ажлын тохиолдол бүрийг хамруулна.”

#### **7/15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт:**

“15.2.3.тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх;”.

#### **8/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:**

“16.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.5, 15.10.6, 15.10.18, 15.10.22, 15.15.1, 15.15.4-т заасан болон мөн зүйлийн 15.14.6 дахь хэсэгт заасан барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд ашиглана.”

#### **9/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:**

“17.1.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах асуудлыг энэ хуулийн 5.1.4-т заасан Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрмээр зохицуулна.”

#### **10/20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт:**

“20.1.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.1.7 дахь заалт болон энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй хуулийн этгээдэд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох болон пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ашиглах, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгох;”.

**4 дүгээр зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “гүйцэтгэх” гэснийг “явуулах” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “боомтыг” гэснийг “боомт, гаалийн хяналтын бүсийг” гэж, 10.2 дахь хэсгийн дугаарыг “5.1.7” гэж, мөн зүйлийн 10.3 дахь хэсгийн дугаарыг “23.2” гэж, мөн зүйлийн 10.4 дэх хэсгийн дугаарыг “12.4” гэж, 11 дүгээр зүйлийн “11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7, 11.1.8” дахь заалтын дугаарыг “11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7, 11.1.8, 11.1.9” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “Зэвсэгт хүчний жанжин штабын” гэснийг “онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын” гэж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “11.1-д” гэснийг “12.1-д” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “24 цагийн дотор” гэснийг “даруй” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “гамшгаас хамгаалах” гэснийг “онцгой байдлын асуудал эрхэлсэн” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг “хуулийн этгээдэд” гэснийг “тэсэрч бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй шууд харьцаж байгаа ажилтны тоо, энэ хуулийн 19.1-д заасан даатгалын талаархи мэдээлэл, тэсэлгээчин, пиротехникийн

хэрэгслийн операторчны бүртгэл, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, тэдгээрт” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн дугаарыг “23.6” гэж, мөн зүйлийн “23.3, 23.4, 23.5, 23.6, 23.7, 23.8” дахь хэсгийн дугаарыг “23.7, 23.8, 23.9, 23.10, 23.11, 23.12” гэж, мөн зүйлийн 23.7 дахь хэсгийн “23.6-д” гэснийг “23.10-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтын “Мэргэжлийн зөвлөлийн” гэсний дараах “санал,” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “экспортлох,” гэсний дараах “худалдах,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “зориулалтын агуулах,” гэснийг, 11.4 дэх хэсгийн хэсгийн “Мэргэжлийн зөвлөлийн” гэсний дараах “санал,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.3.4 дэх заалтын “санал авсан байх” гэсний дараах “ба санал өгөх хугацааг ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэж байх.” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “үед мөрдөх” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1 дүгээр зүйлийн “иргэн,” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “нотолгоог” гэсний дараах “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад долоо хоногийн дотор хүргүүлж,” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын .... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг